

БНХАУ-ЫН НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ ОРЧИН ДАХЬ “МЭДЭЭ УГААХ”  
ҮЗЭГДЛИЙГ ШИНЖЛЭХ НЬ

Дү Сянжүй\*, Сюй Зүгуан \*\*

\*БНХАУ, ӨМИС-ийн Уран Зохиол, Сэтгүүл Зүйн Дээд Сургуулийн багш

\*\*БНХАУ, ӨМИС-ийн Уран Зохиол, Сэтгүүл Зүйн Дээд Сургуулийн магистрант

**Түлхүүр үг:** селф-хэвлэл мэдээлэл, “шампунь” ажиллагаа, нийгмийн сүлжээний зохицуулалт, зохиогчийн эрх

**Товч агуулга:** Интернет сүлжээний хөгжлийн дагуу хүмүүсийн мэдээлэл олох арга зам олширсон. Үүнд БНХАУ-ын ВиЧат (WeChat) платформоор төлөөлөл болгосон нэг бүлэг селф-хэвлэл мэдээлэл (нийгмийн сүлжээ сайтууд) маш түргэнээр хөгжсөн нь мэдээлэл түгээх арга замыг өөрчилжээ. Энэ нь мэдээллийн харилцаа ба солилцооны зардал бага, хүмүүсийн мэдээлэл олох сонголтыг өргөн болгосон байна. Тиймээс нуугдмал чанартай, зардал багтай мөртлөө олон янз хэлбэртэй байдаг “шампунь” ажиллагаа селф-хэвлэл мэдээллийн, тэрчлэн бүх интернетийн хөгжилд сөргөөр нөлөөлсөн асуудал илэрчээ. Үүний гол шалтаан нь энэхүү ажиллагааг хуулийн талаас магадлан тогтооход төвөгтэйгөөс гадна хүмүүсийн ашгийн төлөө хөөцөлдөл их, селф-хэвлэл мэдээллийн хяналт сул байдагтай холбоотой ба түүний нээлттэй чанараас болж хянан шалгах хүч дутагдсан, хэвлэл мэдээллийнхэн болон үзэгчдийн хоорондох хязгаарлах хүчний

дутагдал зэрэг шалтгаанаас болж “шампунь” үзэгдэл селф-хэвлэл мэдээлэлд газар авсан байна.

**“Шампунь” үзэгдлийн тухай.**

“Шампунь” гэх үг бол хуулийн нэрийтгэл биш, харин сэтгүүл зүйн үг юм. Энэ нэр томъёонд хоёр зүйлийн ойлголт байдаг. Нэг нь сэтгүүлчээр бусад хэвлэл мэдээллийнхний цацсан мэдээллүүд дээр тулгуурлан нийтлэл бичиж нийтлүүлэх, бусад хэвлэл мэдээллийн сэтгүүлчтэй хамтран ажиллахыг хэлнэ. Тухайлбал тусдаа ярилцсаны дараа нийтлэлээ солилцон өөр өөрсдийн мэдээний байдлыг үндэслэн нийтлэл бичиж нийтлүүлэхийг хэлнэ<sup>1</sup>. Нөгөө нь, хэвлэл мэдээллийнхэн (онцгойлон мэдээний сайтууд) янз бүрийн аргаар нийтлэлийг олонтаа засах эсвэл өөр газар дамжин нийтлэнхдээ мэдээний жинхэнэ утгыг баллан, зохиогчийн эрхийн зөрчлөөс зайлдаг аргыг хэлнэ<sup>2</sup>. Өнөөгийн хэвлэл мэдээллийнхний анхааралд орсон “шампунь” бол голдуу хоёр дахь ойлголт дээр яригдаж байна. Сүүлийн үед, ВиЧатаас “шампунь”-ийн асуудалд анхаарч гомдлын механизм туршин хэрэглэхдээ “шампунь”-ийг магадлах стандарт гаргажээ. Эдгээр нь ижил сэдэвт адилхан үзэл бодолтой байх эсэх;


Үсэг, зураг зэргийг багтаасан хоорондоо адилавар мэдээллийн бус материалуудыг хэрэглсэн эсэх; агуулгын бүтэц, зохиолын баатруудын хоорондох харьцаа, дедукцийн сэтгэхүй зэргийг багтаасан адиливар илтгэх арга барил эсвэл логик хэрэглэсэн эсэх; ижил утгатай үгээр сольсон эсэх, үгсийн дарааллыг хувиргасан эсэх, хэсгийн агуулгыг сольсон эсэх, түлхүүр үгсийг нэмж хассан эсэх зэрэг аргаар магадлана<sup>3</sup>.

“Шампунь”-ийг их төлөв хоёр төрөлд хувааж болно. “Илтгэх аргыг нь ашиглах шампунь” буюу бусдын бүтээлийн бүтэц, логик, дүрийн зохиомж, орчин тойрны зохиомж, үлгэрийн зохиомж, үг үгсийн илтгэмж гэх мэт элементүүдийг ашиглах, тухайлбал бусдын илтгэмжийг шууд хуулахыг хэлнэ. Ийм “шампунь” нь харьцангуй доод түвшнийх юм. Нөгөө нэг төрөл нь “үзэл санааг ашиглах шампунь” буюу бусдын зохиолын гол сэдэв, хэрэг жишээ эсвэл үзэлт зэрэг элементүүдийг ашигладаг. Тэд голдуу бусдын үзэл санааг хуулдаг

болохоор “дээд” түвшний “шампунь”-д багтана<sup>4</sup>.

**Селф-хэвлэл мэдээллийн “шампунь” үзэгдэл.**

**Зохиогчийн эрхэнд халдах үзэгдэл газар авав.** 2018 оны нэгдүгээр сарын “Жоу Чун-ний шампунь хэрэг”-ээс хойш “шампунь” үзэгдэл нь олны анхаарлыг их татжээ. Мөн 2018 оны тавдугаар сард үүссэн “Tencent” компанийн “Ча Пин”-д хөрөнгө оруулсан учир, бас 2019 оны хоёрдугаар сард үүссэн тоглогч Жай Тянь Линь диплом хуулсан учир нь “шампунь”-ийн тухай асуудлыг салхины аманд авчирчээ. Интернет дэх зохиогчийн эрх, ялангуяа зохиолын агуулгыг хамгаалах зорилготой ашгийн бус холбоо “Rightknights” сайтын статистикаас үзвэл, зохиол бүрийн зохиогчийн эрхийг дунджаар 7 удаа зөрчсөн байна. Тэд 2018 онд БНХАУ-ын зохиогчийн эрхийн үндэсний байгууллагын зөвшөөрлийг олж, Хятадын зохиогчийн эрхийн нийгэмлэгт элсжээ. “Rightknights” нь тогтсон хугацаатайгаар зохиогчийн




**Зураг 1.** 2018 оны хоёр, гуравдугаар улиралд зохиогчийн эрх зөрчсөн ажиллагаа үүссэн процент.

эрхийн тайлан бичиг хийдэг, харин тайлан дах статистик нь холбооны гишүүдээс, тус сайтын өөрийн бүртгэлээс ба интернетэд нийтлэгдсэн тоо баримтаас эрэлттэй байдаг. Тус сайт 2018 оны хоёр, гуравдугаар улирлын тайландаа зохиогчийн эрх зөрчсөн ажиллагаа үүссэн статистикийг *Зураг 1-д* харуулав<sup>5</sup>. Гуравдугаар улиралд үүсэн зохиогчийн эрх зөрчсөн норм нь хоёрдугаар улирлынхаас хоёр дахин илүү байх нь энэ үзэгдэл маш түгээмэл болж буйг

харуулж буй. Үүнээс гадна, ВиЧатын палтформнуудын дунд зохиогчийн эрх зөрчсөн жишээ 498, 155 хүрч (2018.7.1-2018.9.30 хүртэлх хугацааны бүртгэл), зохиогчийн эрх хүнд зөрчигдсэн орон болжээ.

### 1. Зохиогчийн эрхийг хамгаалах орчин нөхцөл муу байна


Дараагийн зураг бол “Right knights”-ийн хийсэн селф-хэвлэл мэдээлэл дэх зохиогчийн эрх зөрчсөн байдлын статистик<sup>6</sup> юм.




**Зураг 2.** Селф-хэвлэл мэдээлэл дэх зохиогчийн эрх зөрчиж байгаа байдал.




**Зураг 3.** Селф-хэвлэл мэдээлэл дэх зохиогчийн эрх зөрчсөн байдал.



**Зураг 4.** Бие даасан эрхийн хамгааллын ялах боломж бага байна.



**Зураг 5.** Эрхийн хамгааллын зардал өндөр байгаа нь хамгийн том бэрхшээл.



**Зураг 4.** Эрхийн хамгааллын хүсэлт хоёр хуваагдсан.

Дээрх судалгаанаас үзвэл хагас илүү тооны зохиолч зохиогчийн эрх зөрчигдсэн, тэдний олонх хүмүүс зохиогчийн эрх зөрчсөн ажиллагааг эсэргүүцдэг боловч өнөөгийн нөхцөл байдлаас болж ямар ч арга авч чадаагүй байна. Зохиолчдын 46% нь зохиогчийн эрх нь зөрчигдсөний дараа идэвхтэйгээр эрхээ хамгаалах оролдлого хийсэн ч үлдсэн нь эрхээ хамгаалахын оронд үл мэдэг болж, ийм байдалд дассан байна. Хамгийн харамсалтай нь эрхээ хамгаалах ажиллагаа ялах боломжоор бага байгаа учир билээ. Зохиогчийн эрхийг хамгаалахад хамгийн тохиромжтой үр дүн бол нөхөн олговор. Гэвч одоогийн байдалд олонх зохиолчид зөвхөн зохиогчийн эрхээс зөрчсөн “зохиол”-ыг устгахыг л шаарддаг. Зохиогчийн эрхээ хамгаалах аргын хувьд “гуравдагч этгээдийн зохиогчийн эрхийн үйлчилгээ үзүүлэгч” болон “хамаарах платформд найдан шийдвэрлэх” хоёр зүйлийн арга бол голдуу хэрэглэгдэж байна. “Өөрөө харьцаж шийдвэрлэх” ба “шүүхэд заалдах”-ыг сонгодог зохиолчид

хараахан цөөн байна. Түүнчлэн “Yidianzixun” мэтийн платформууд техник мэргэжлийг ашиглан бусдын эх материалыг өөрийнхөө дур зоргоор шилжүүлсэн байдлыг дурдах ёстой. Аль 2016 онд тус платформыг зуу гаруй нэрийн селф-хэвлэл мэдээллийнхээс техник мэргэжлээр бусдын зохиолыг хуулсан учраар заалдаж өнгөрсөн түүхтэй.

## **2. Магадлан тогтоох нэгдсэн стандарт дутагдаж байна.**

Зохиогчийн эрхийг хамгаалах ажлыг гүйцэлдүүлж буй байдлыг үзвэл эл платформуос эх зохиолыг ба “шампунь”-ийг ялгах арга хэлбэр, стандарт болон хурдац зэрэг нь ондоо мөртлөө, платформ дамжин байж шийдвэрлэх нь хэцүү байдгаар барахгүй бүтэмж муутай байдаг. Үүнээс гадна Хятадын “шампунь”-тай холбогдох хууль тогтоол бүрэн бус, одоохондоо голдуу “Мэдээний Сүлжээний Холболтын Эрхийг Хамгаалах Журам”-ыг мөрддөг. Гэвч энэ журамд селф-хэвлэл мэдээлэл зохиогчийн эрх зөрчих байдалд хэрэгжүүлэх аргыг нарийн

бичиж оруулаагүй<sup>7</sup>. Түүнчлэн зохиогчийн эрхийн хуульд “хулгайлах” ажиллагаа нь хуулийн хариуцлага хүлээх ёстой хэмээн дурдсан хэдий ч энэхүү “хулгайлах” ажиллагааг магадлан тогтоох тодорхой агуулга байхгүй байна.

Дээрх байдлаас хураангуйлбал, селф-хэвлэл мэдээллийн “шампунь” үзэгдэл өнөөг хүрэхэд нэгэнтээ энэ салбарын түгээмэл үзэгдэл мэт болсон нь зохиогчдын зохион бичих урам төдийгүй, бүхий л селф-хэвлэл мэдээллийн хөгжил төлөвшилд ноцтой харшилжээ. Хэрэв энэ байдлыг хориглон зогсоохгүй бол эцэстээ селф-хэвлэл мэдээллийн дампуурал болж, илүү том асуудал бий болох нь дамжиггүй.

**Селф-хэвлэл мэдээлэл дэх “шампунь”-ийн онцлог.** 2019 оны хоёрдугаар сарын эхэнд үүссэн тоглогч Жай Тянь Линь диплом хуулсан хэрэг нь селф-хэвлэл мэдээллийн салбарт үүссэн хэрэг биш хэдий ч, олны халамшил болсон энэхүү хэрэг нь “шампунь”-ийн онцлогтой тул бидний жишээ болгон задлахад тохирно. БНХАУ-ын интернет сүлжээний платформ болох “Пэн Пай мэдээлэл”-ийн нэг мэдээллээс доорх харьцуулсан агуулгыг энд сонгон оруулав (агуулгын хоорондох ялгаатай хэсгийг харлуулжээ).

**Т**оглогч Жай Тянь Линий магистрын дипломын ажилд өгүүлэхдээ “Кино, телевизийн жүжигт бодитой мөртлөө өөрийн онцлог бүхий, үзэгчдэд гүн суугдал үлдээж чадах урлагийн дүр бүтээх нь **шилдэг тоглогч бүхний тэмүүлэл мөн.** Тэгвэл, дүрийнхээ дотоод гаадаад онцлогийг тоглох явцдаа хэрхэн бариж аван, **цаашдаа** тэдгээр онцлогуудыг илрүүлэхийн зэрэгцээ бусад адиливтар

дүрүүдээс ялгагдах, түүний өөрийн онцлог бүхий хөдөлгөөн, үг яриа, үзэл санааг бий болгох **ёстой вэ?** Тоглолтондоо жүжигчин хүн хэрхэн өөрийгөө харуулах биш харин дүрийгээ харуулах **ёстой вэ? Үүний хариулт нь яг Дүрийн зан чанрыг бий болгоход оршино**”<sup>8</sup> гэжээ. Жүжигчин Чэн Куний магистрын дипломын ажилд өгүүлэхдээ “Кино, телевизийн жүжигт бодитой мөртлөө өөрийн онцлог бүхий, үзэгчидэдэд гүн суугдал үлдээж чадах урлагийн дүр бүтээх нь **“тоглогч”-оор өөрийн ажлаа болгож байгаа бид бүхний тэмүүлэл.** Дүрийнхээ дотоод гаадаад онцлогийг тоглох явцдаа хэрхэн барьж аван, тэдгээр онцлогуудыг илрүүлэхийн зэрэгцээ бусад адиливтар дүрүүдээс ялгагдах, түүний өөрийн онцлог бүхий хөдөлгөөн, үг яриа, үзэл санааг бий болгох, тоглолтондоо тоглогч хүн хэрхэн өөрийгөө харуулах биш харин дүрийгээ харуулах гэсэн хоёр асуултанд хариулт өгвөл **Дүрийн зан чанарыг бий болгох**”<sup>9</sup> гэжээ. Зохиогчоос энэхүү жишээг задлан селф-хэвлэл мэдээлэл дэх “шампунь”-ийн онцлог шинжийг дүгнэжээ.

**“Шампунь”-ийн өгүүлбэр амархан мэдэгдэхүй.** “Шампунь” бол энгийн хуулах ажиллагаанаас ялгаатай мөртлөө амархан мэдэгддэггүй байдаг. Түүний агуулга нь үг үсэг аль эсвэл үг үсгийн цаанах гол үзэл санаа бүр байж болно. Селф-хэвлэл мэдээлэл дэх “сайн угаасан” зохиолын өгүүлбэрүүд нь эх зохиолын өгүүлбэрүүдээс бүр ондоо, мэдэгдэхгүй байж болно. Жишээлбэл, Жай Тянт Линиэс Чэн Куний “тоглогч”-оор өөрийн ажлаа болгож байгаа бид бүхний тэмүүлэл” гэх өгүүлбэрийг “шилдэг тоглогч бүхний тэмүүлэл мөн” хэмээн сольсон, дүрийн зан чанарыг бий болгох тухай өгүүлбэр

дэх зураасыг жишэн асуух өгүүлбэрээр сольсон, бас өгүүлбэрийн гол санаанд нөлөө болохуйц үг нэмсэн зэргийг дурдаж болно.

**“Шампунь”-ийн зардал бага.** “Шампунь”-ийг хүний хүчээр “угааж” болох мөртлөө программаар “угааж” болдог. Зохиогчоос зарим нэг сайт дээр “шампунийн багаж” гэж хайхад хэдийгээр харгалзсан зүйл нэг л олдсон ч, үүний дагуу сайтаас холбон бодолтоор дамжуулан их хэмжээний 5-50 юаний хорондох таваарнуудыг танилцуулсан байна. Тэдний үнэ нь дээшээ хязгаар байдаггүй. Иймэрхүү “шампунь”-д үйлчилдэг программууд их олон мөртлөө хямдхан байдаг юм. Үүнээс гадна, хүний хүчээр “угаах” арга нь ч эх зохиолынх шиг их хэмжээний бэлтгэл ажил хийх чухалгүй, харин эх зохиолын өгүүлбэрүүд болон үзэл санааг шууд ашигладаг болхоор “шампунь” ажиллагааны бэрхшээл болон зардлыг бага болгожээ. Зохиогч Цюн Яогоос найруулагч Юй Жэнийг заалдсан хэргийн жишээнээс үзвэл, телевизийн цуврал “Их ордон: Лянь Чэний хувь тавилан” дахь Хэн Тай, Лянь Чэн болон Син Дай гүнжийн хоорондох гол үлгэр нь зохиогч Цюн Яогийн “Сорви” гэх бүтээл дэх Хао Жэнь, Инь Шуан, Лань Синь гүнж зэрэг зохиолын гол баатрын ирэл гарал жич тэд гурвуулын хоорондох харьцаатай эгээ адилхан гэж хэлж болмоор. Цуврал дах жанжин, фүжин хатан, жигүүрийн фүжин хатан болон эгэл гаралтай хүү зэрэг хүмүүсийн дүрүүд нь өөрчлөгдсөнийг гаргавал, бусад дүрүүдийн хоорондох харьцаа нь “Сорви”-ийнхтай яг адилхан байлаа. Гол үлгэрт Лянь Чэн болон Хэн Тай, Син Дай гүнж гурвын хайр дурлалын үлгэр, Хэн Тай шинэ хуримынхаа шөнөдөө Лянь Чэнтэй уулзахаар очсон, Лянь Чэнийг үнэгэн

шулам хэмээн хилстүүлэн тамалж номчоор ном уншуулсан зэрэг явцыг “Сорив” гэх зохиолоос уг хэвээр нь хуулжээ<sup>10</sup>.

**“Шампунь”-ийн арга хэлбэр олон янз байдаг.** “Шампунь” нь аппаратаар зохиолын агуулгыг өөрчлөх, олон зохиолыг нийлүүлэх, адил бус цаг үеийн агуулгыг зүйн нийлүүлэх, зохиолын нэг хэсэг агуулгыг ашиглах, гол үзэл санааг хулгайлах гэх мэт аргаар багаас өгүүлбэр, ихээс үзэл санааг хүртэл хулгайлдаг. Мөн тэдний мэргэжил дээшилснээс болж “шампунь”-ийг ялган таних бэрхшээл явах тусам нэмэгдэж байна. Найруулагч Лю Ялин өөрийн блогдоо найруулагч Юй Жэний хуулах аргыг илчэлснийг сийрүүлбэл: “Түүний хэлэхээр 20 хувиас хэтрэхгүй бол шүүхээс хариуцлага нэхэмжлэхгүй, жишээлбэл бусдын 20 бүлэгтэй цувралын бүхнийг хуулчихаад түүнийгээ 100 бүлэгтэй болговол болчихно”. Лю Ялиний энэ үг үнэн болохыг уул нь Юй Жэнтэй хамтарч өнгөрсөн найруулагч Зоу Жэн гэрчилсэн байна<sup>11</sup>.

**Селф-хэвлэл мэдээлэл дэх “шампунь” бий болсон шалтгаан.**

1. *Селф-хэвлэл мэдээллийн платформын хянан хамааралтын асуудал.* Ойрын жилүүдэд эл их селф-хэвлэл мэдээллийнхэн зохиогчийн эрхийг хамгаалахаар олон арга авсан хэдий ч тэдний олонх нь хуулах үзэгдэлд өөрийн анхаарлаа хандуулснаас биш харин “шампунь”-д хандуулсан тусгай арга гаргаж чадсангүй. Тэр мөртлөө ихэнх платформуудын эх зохиолыг хамгаалах арга нь зөвхөн механик маягаар дубликат шалгах төдий. Гэхдээ хэрэв эх зохиолын агуулгын дэс дарааллыг өөрчлөх эсвэл ауулгад нэмэлт хасалт хийвэл энэхүү

дубликат шалгах арга нь үйлдлээ алдахад хүрдэг байна.

Денис МакГуайлс “Audience Analysis” зохиолдоо “Харилцааны шинэ технологийн нөөлөн дор үзэгчдийг “жижиглэх” хийгээд “хуваарилах” хандлага зайлшгүй бий болно”<sup>12</sup> гэжээ. Өнөөгийн интернетийн эринд селф-хэвлэл мэдээлэлд их олон янзын платформууд байдаг. Үзэгчид эдгээр платформуудад “жижиглэгдэн”, анхаарал нь хуваагдсанаас болж нэг зохиол адил бус платформуудад давхардсан ч амархан мэдэгдэхгүй болжээ. Гэвч эл платформын хооронд одоо хүртэл агуулгын хянан хамааралттай холбогдох харилцаа холбооны механизм илрээгүй болохоор тус салбарт платформ дамнасан зохиогчийн эрхийг хамгаалах холбоол байгуулах шаардлага тулгарчээ. Бас селф-хэвлэл мэдээлэл их түгээмэл болсон учраас түүний нэвтрүүлэгч нь бас тусгай мэргэжлийн байснаа одоо олон нийтийн шинжтэй болсон байна. Үүнээс гадна, өнөөгийн селф-хэвлэл мэдээлэлд урсгал болсон зохиолуудын олонх нь ганц нэг хүний зохиосон юм биш, харин харилцааны явцад тасралтгүй баялагжсанаар бий болсон юм. Энэхүү явц дахь зарим зүй бус ажиллагаанаас болж эцэстээ анхны зохиогч нь хүртэл олдохгүй болдог<sup>13</sup>.

Эдгээр шалтгаанууд “шампунь”-ийг бий болгосон гэж хэлж болно. БНХАУ-ын селф-хэвлэл мэдээллийн нэг болох ВиЧатын шинээр туршин хэрэглэж байгаа гомдлын коллежийн механизмын өнөөгийн байдлаас үзвэл, тэрбээр сүр нь үйлдлээсээ их юм болох аюултай байна.

2. “Хаалгач” хүний үзүүлэх үйлдэл бага болсон. Селф-хэвлэл мэдээллийн эрин ирсэнээс хойш тусгай мэргэжлийн “хаалгач” хүний дутагдлаас

болж селф-хэвлэл мэдээлэл хийдэг хүмүүсийн тусгай мэргэжлийн боловсролын түвшин өндөртэй богинотой болсноор барахгүй, хэвлэл мэдээллийн хамаатай тусгай сургалт ба практик, тус салбар дахь “шампунь”-ийн зөв үү буруу юу гэдгийн талаарх зөвшилцөл бас тусгай мэргэжлийн чанартай хэвлэл мэдээллийн олон ажлын явц дахь аль олон хянан шалгалтын дутагдлаас болж хүмүүс “шампунь”-ийг харилцааны энгийн нэг зүйлийн арга гэж үзэхэд хүрчээ<sup>14</sup>.

Селф-хэвлэл мэдээлэл дэх харилцааны субъект тогтвортой биш байдаг мөртлөө тусгай мэргэжлийн бус хэвлэл мэдээлэл нь ихэнх тоог эзэлдгээрээ уламжлалт хэвлэл мэдээллээс ялгагдана. Селф-хэвлэл мэдээллийн харилцаа тун эрх чөлөөтөй, үүнд хувь хүмүүсийн хоорондох харилцаа, олон нийтийн харилцаа бол түүний харилцааны онцлог. Нийтлэх агуулгын хувьд маш өргөн дэлгэр, дотор нь нийтлэл ба хувь хүний нууц бүхий агуулга бүр багтдаг. Харин түүний харилцааны объектыг тодорхой мөртлөө тодорхой бус гэж хэлж болно. Учир нь селф-хэвлэл мэдээллийн нийтэлсэн мэдээллийг ямарваа нэгэн хүн бүр үзэж болох мөртлөө ямар ч шаардлага байдаггүй, иймээс түүний үзэгчид нь тогтвортой бус юм. Гэхдээ нэгэн амжилттай селф-хэвлэл мэдээлэл нь их олон шүтэгч, дагалдагчтай байдаг. Эдгээр шүтэгч хүмүүс бол ердөө ямар нэгэн хамтын дур сонирхол эсвэл хамтын сэдвээс болж нэг селф-мэдээллийн дор цугладаг, иймээс түүний үзэгч нь мөн тодорхой байдаг. Үүнээс гадна, селф-хэвлэл мэдээллийн орчин дотор хүн бүхэн мэдээллийн харилцааны оролцогч болж болно. Тухайлбал, селф-хэвлэл мэдээллийн төв-зах хэмээх харилцааны загварын



дагуу, мэдээлэл түгээгч нь мэдээллийн эх болсны хувьд мэдээллээ үзэгчдэд түгээнэ, үзэгчид зангилаа цэг болсны хувьд бусад хэрэглэгчдийн мэдээллийг хүлээн авах мөртлөө бусад хэрэглэгчид рүү мэдээлэл түгээж болдог, зангилаа цэгүүдийн хоорондох харилцаагаар дахин шинэ мэдээлэл үүсдэг байна. Мөн иймэрхүү процессоор “зангилаа цэгүүдийн хамтын хэрэглээний” мэдээллийн харилцааны сүлжээ бүрэлдсэн юм.

Үүнээс бид селф-хэвлэл мэдээлийн хяналтын механизм харилцааны явцдаа их суларсныг олж харана. Уламжлалт хэвлэл мэдээллийн цаг үе дэх мэдээлэл нь дан чиглэлийн түгээлт болхоор түгээгч болон үзэгчдийн хооронд тодорхой зааг хязгаартай байдаг. Мөн уламжлалт хэвлэл мэдээлэл дэх мэдээллийн түгээлтийг эл зэргийн “хаалгач” хүмүүс шийддэг учраас тэд мэдээллийг захирах эрх мэдэлтэй<sup>15</sup>. Учир иймээс уламжлалт хэвлэл мэдээллийн үед “шампунь”-д хандуулсан хууль дүрэм, тэрчлэн “шампунь”-ийг магадлан тогтоох стандарт байсангүй боловч, “хаалгач” хүн “шампунь” зохиолыг амархан таньж чаддаг байснаар зохиогчийн эрх зөрчсөн агуулгын түүгээлтийг хориглож чаддаг байсан.

Шинэ хэвлэл мэдээллийн илэрхий нэг онцлог бол түүний харилцан үйлдэл болно. Үүнд харилцан үйлдэл гэдгийг хоёр зүйлийн утгаар ойлгож болно. Нэг нь, мэдээлэл түгээгч болон хүлээн авагчийн хооронд мэдээллийн солилцоо нь хоёр чиглэлтэй байдаг. Нөгөө нь, мэдээллийн солилцооны явцад оролцсон хувь хүн болгон мэдээллийг эзэмдэх эрхэтэй байдаг<sup>16</sup>. Ийм харилцан үйлдэл нь уламжлалт “хаалгач”-ийн мэдээллийн

хяналтад үзүүлэх нөлөөг алхам алхмаар бууруулж байна.

3. *Мэдээллийн хоёр талд хандуулсан чанга дүрэм дутагдаж байна.* Селф-хэвлэл мэдээлэл дэх мэдээлэл түгээгч ба үзэгчид хоёр талын харьцаа хийсвэр шинжтэй байдаг нь мөн ч шинэ хэвлэл мэдээллийн онцлог болно. Уламжлалт хэвлэл мэдээлэл дэх хоёр талын хүмүүс нь тодорхой тул мэдээллийн эх сурвалж нь ч тодорхой байдаг. Харин селф-хэвлэл мэдээлэл дэх хоёр талын хүмүүс нь хийсвэр шинжтэй тул тэдний хоорондоо солилцох мэдээлэл ч тодорхой бус байдаг. Яг ийм хийсвэр шинжээс шалтгаалан селф-хэвлэл мэдээллийн хүн “шампунь” хийх үедээ хуульд олноороо ял хийхийг ялд тооцохгүй гэсэн үзэлтэй болсон мөртлөө тэдний ёс суртахууны үзэл ухамсар явах тусам доошилж бий.

Үзэгчдийн хувьд эх зохиол мөн эсэх нь тэдний унших сэтгэгдэлд онц их нөлөөлдөггүй. Ричард Поснер “The little book of plagiarism” номдоо “(зугаа цэнгэлийн бүтээл сонирхохдоо) уншигчдын тэрхүү бүтээл нь эх бүтээл мөн болох эсхийг сонирхох сонирхол нь зочдын ширээн дээрх хоол нь эх бүтээлч шинжтэй эсэхийг сонирхохоос илүүгүй байдаг”<sup>17</sup> гэжээ. Селф-хэвлэл мэдээллийн нээлттэй байдал нь нэг бүлэг үзэгчдийн хэрэгцээг хангасан болохоор зарим селф-хэвлэл мэдээллийнхэн “шүтэгч” хүмүүстэй болжээ. Гэвч эдгээр “шүтэгчид” нь тус платформын “шампунь” ажиллагааг мэдсэн ч үл мэдэгчийн янз гарган, ийм ажиллагааг эсэргүүцэх биш харин үргэлжлүүлэн дэмждэг байна. Энд 2018 оны эхэнд үүссэн “шампунь”-ийн маргаанаар жишээ татвал, “Шампунь”-ийн сэжиглэлтэй селф-хэвлэл мэдээллийн шүтэгчид интернет дээр их хэмжээний үндэслэлгүй яриа нийтэлж,

тэрчлэн зарим нь “шампунь” ажиллагааг илээр дэмжжээ<sup>18</sup>. Ийм байдлаас үзэхэд, ёс суртахууны талаас “шампунь”-ийг хориглоход харьцангуй хүчир болжээ.

4. *Хуулийн талаас магадлан тогтооход бэрхшээлтэй байна.* “Шампунь” ажиллагааг зохиогчийн эрх зөрчсөнөөр магадлан тогтооход хоёр саад бий. Нэг нь, БНХАУ-ын өнөөгийн хууль тогтоол арай бүрэн төгс биш байсаар, нөгөө нь, зохиогчийн эрхээ хамгаалах зардал дэндүү өндөр болохоор хичээл зүтгэл болон үр ашгийн харьцал тэнцүү бус байсаар. “Зохиогчийн эрхийн хууль”, “Мэдээний сүлжээний холболтын эрхийг хамгаалах журам” бол одоохондоо интернет дэх зохиогчийн эрхийг хамгаалах ажилд ашиглаж болох хууль дүрэм болно. Гэвч эдгээр хуульд зохиогчийн эрхийг зөрчсөн эсэхийг магадлан тогтоох стандарт, хэрхэн шийтгэх зэрэг талаарх тодорхой дүрэм байхгүй байсаар. Манай улсад хэдийгээр дижитал нийтлэлийн талаарх макро түвшний хууль нэлээд олон боловч бодитой хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй юм. Бас шүүхийн заргалдаанд цахим гэрч баримтыг өөрчлөх эсвэл устгахад амархан, хадгалахад хэцүү, түүнээр гэрч болгоход төвөгтэй зэрэг асуудал оршсоор байгаа нь зохиогчийн эрхийг зөрчсөн эсэхийг магадлан тогтооход бэрхшээл учруулсан байна. Үүнээс гадна, хууль бус ажиллагааны зардал болон зохиогчийн эрхийн хамгааллын зардлын хоорондох зөрүү дэндүү ихээс болж эрхээ хамгаалагчдын орлого нь зардалдаа хүрэхгүй байх боломжтой ба эх зохиолын зохиолчийн эрэмшүүлсэн ажиллагаа нь “шампунь”-ийн муу нөлөөг улам их болгожээ.

**Б**НХАУ-ын зохиогчийн эрхийн хуулийг хэрэгжүүлэх тогтоолын хоёрдугаар зурваст “Зохиогчийн эрхийн хууль дахь бүтээл гэдэг нь уран зохиолын, урлагийн ба шинжлэх ухааны хэвчээ дэх өвөрмөц шинж бүхий ямар нэгэн хэлбэрээр хуулбарлаж болох оюуны бүтээлийг заана”<sup>19</sup> гэжээ. Иймээс селф-хэвлэл мэдээллийн платформ дах эх зохиол нь өгүүлбэрийн өвөрмөц шинжтэй болохоор зохиогчийн эрхийн хуулийн хамгааллыг хүртэх ёстой. Гэхдээ “шампунь” нь энгийн хулгай ажиллагаанаас ондоо, тэрбээр ижил утгатай үгээр солих, өгүүлбэрийн дэс дарааллыг өөрчлөх, агуулгыг нэмж хасах зэрэг аргаар эх зохиолын өвөрмөц шинжтэй өгүүлбэрийг маш амархнаар сольдог байна.

Зохиогчийн эрхийн хуульд нэг зохиол нь зохиогчийн эрхээс зөрчсөн эсэхийг магадлахдаа ердөө “Үзэл бодол ба өгүүлбэрийн дикотом”-ийн зарчмыг мөрдөж, бодитой хэрэглээнд бол “мэдээллийг ойлгосон байдал + бодит ижил төстэй байдал”-ын аргаар магадлалт хийдэг. Мэдээллийг ойлгосон байдал гэдэг нь зохиогчийн эрх нь зөрчигдсэн зохиолын мэдээллийг зохиогчийн эрх зөрчсөн сэжигтэй хүн хэр зэрэг олсон эсвэл ойлгосон байдлыг заана. Бодит ижил төстэй байдал гэдэг нь хулгай хийснээр заалдагдсан бүтээлийн агуулга нь өгүүлбэрийн өвөрмөц шинжийн талаар бусдын бүтээлтэй ижил төстэй эсвэл ойролцоо болсон байдлыг заана. Үүнд хэлж байгаа ижэл төстэй эсвэл ойролцоо байдал бол олон нийтээс хоёр зохиолыг хутгах хэмжээнд хүрүүлдэг. Дээрх хоёр байдлыг бүрэлдүүлсэн нөхцөл дор “шампунь” нь зохиогчийн эрхийг зөрчсөнд тооцогдоно. Жишээлбэл, нэг зохиолд ямар нэгэн үзлийг тайлбарлахад А+В+С зэрэг

материалуудыг ашигласан байхад, нөгөө нэг зохиол нь мөн А,В,С эсвэл төстэй материалыг хэрэглэжээ. Тус хоёр зохиолын адил бус тал гэвэл сүүлийн зохиол нь ашигласан материалынхаа дэс дарааллыг өөрчлөх, ашиглах материал нэмэх, А,В,С-гийн агуулгатай төстэй материалуудыг ашиглах, аль эсвэл өөрийн үгээр бусдын үзэлтийг илтгэн, дээр нь бага зэрэг өөрийн онцлогтой агуулга нэмэх зэрэг аргыг хэрэглэдэг, гэхдээ түүний гол үзэл санаа нь мөн бусдынх юм. Ийм хэлбэрийн “шампунь” нь зохиогчийн эрх зөрчсөн эсэхийг бид бас цаашид судлах хэрэгтэй. Үүнд “шампунь” нь үзэл бодол хуулийн хамгаалалтанд багтахгүй зарчимд тулгуурлан өгүүлбэрийн илтгэх аргыг өөрчилж байх нь зохиогчийн эрх зөрчсөн эсэхийг магадалахад төвөгтэй болгожээ. Иймээс “үзэл бодол” болон “илтгэх үг өгүүлбэр”-ийн хоорондох зөрчлийг зөв шийдэх нь хуулийн талаас “шампунь”-ийн асуудлыг шийдвэрлэх түлхүүр болно.

5. *Эдийн засгийн ашгийн хөөцөлдөл.* “Хятад ард улсын интернет сүлжээний хөгжилтийн байдлын статистикийн тайлан”-гаас үзвэл, 2018 оны 6-р сар хүртэл, интернет хэрэглэгчийн тоо нэгэнтээ 820 сая хүрч, интернет сүлжээ түгээмэлжсэн процент нь 57.7% хүрсэн байна. Селф-хэвлэл мэдээлэл түргэн хөгжиж, платформ дахь хэрэглэгчдийн тоо тасралтгүй өссөнөөс хойш, оператор нар олон шүтэгчтэй болохын тулд эсвэл өөрийн платформ дахь шүтэгчдийн тоо их байдаг давуулгыг ашиглан бизнесийн хамтын ажиллагаа эрэлхийлдэг болсноор тэдний дунд хурц шүрүүн өрсөлдөөн үүсчээ. Нэг зохиолыг зохион бичихэд урьдаар ямар үг өгүүлбэр сонгох, ямар үйл явдал оруулах зэргийг урт удаан цаг хүч зарцуулан байж сэтгэн бодож

ажилладаг. Үүний зэрэгцээд селф-хэвлэл мэдээллийнхэн ширүүн өрсөлдөөн дунд хөл тогтож чадах гэвэл заавал их хэмжээний шүтэгчтэй болж, “шүтэгчийн бизнес”-ийг бий болгосон байх хэрэгтэй. Энэхүү бизнесийн ашиг олох хэлбэр нь зохион бүтээх-үзэгчдийн анхаарлыг татах, уншлагын тоог нэмэгдүүлэх-үзэгчдийн шан харамж ба зар сурталчилгааны орлого олох гэх маягаар явагддаг.

**С**елф-хэвлэл мэдээлэл бол мөн ч “масштаб бизнес” болно. Учир нь түүний үйлдвэрлэлийн хэмжээ болон зардал хоорондоо урвуу харьцаатай байдаг. Уламжлалт маягийн цаасан хэвлэл мэдээлэлтэй харьцуулбал селф-хэвлэл мэдээллийн хэвлэлийн зардал маш бага байдаг болохоор энэ нь мэдээллийн хэмжээг тэсрэлтийн хэлбэрээр өсгөжээ. Энэ өсөлтийг гаднаас нь авч үзэхэд, үзэгчдийн хүлээж авах мэдээлэл баялагжиж, сонголт олон болсон боловч мэдээлэл нийтлэгчийн болон найруулагчдын нас, ирэл гарал, боловсролын түвшний адил бус байдал мөн мэдээлэл нийтлэгчдийн зорилго ондооноос болж их хэмжээний хуурмаг хоосон мэдээлэл селф-хэвлэл мэдээлэлд илэрчээ. Иймээс мэдээллийн ижилшил, шилдэг зохиолын хомстол нь тэсрэлтийн хэлбэрээр нэмэгдэх мэдээлэлд оршиж байгаа асуудал билээ. Үзэгчид ямар нэгэн мэдээллийг эсвэл платформыг сонгохдоо, тэдний сонголт нь голдуу лайк, уншсан тоо, шүтэгчдийн тоонд суурилдаг. Гэхдээ оператор нарт шилдэг зохиол найруулан зохиох хүрэлцэхүйц цаг, хүч, мөнгө байхгүй учраас “шампунь” нь тэдний нэг гарах зам болжээ. Хэрэв селф-хэвлэл мэдээллийнхэн эх зохиолын зохиогчийн зөвшөөрлийг олох гэвэл хүлээх явцдаа их хэмжээний хүний хүч ба

мөнгө зарцуулах мөртлөө зөвшөөрөл олж чадах эсэх нь ч тодорхойгүй байдаг. Харин ашигаа хамаг их хэмжээнд батлах үүднээс, шилдэг зохиолын агуулгыг шууд авч найруулах эсвэл “шампунь” хийвэл зардлаа багасгаж болохоор барахгүй ашиг олзын максимаацийг биелүүлж чадна. Зохиолын зохиолч мэдсэн байдал дор ч нийтэлсэн зохиолыг устгах, хамаг муу байдал нь ч төлбөр төлөх төдий хэрэг юм. Тэр үед тэд өөрийнхөө зорилтондоо нэгэнт хүрчихсэн байж мэднэ. Дээр тэмдэглэсэнчлэн зохиогчийн эрхээс зөрчих зардал нь ашиг олох зардлаас бага байхаас болж тун олон селф-хэвлэл мэдээллийн хүмүүс “шампунь” хийх болсон байна.

## **С**елф-хэвлэл мэдээллийн “шампунь” үзэгдлийг хориглох стратеги.

1. *Селф-хэвлэл мэдээллийн дотоод дахь хувийн сахилга батыг чангатгаж, хяналтын байгууллага байгуулах.* Селф-хэвлэл мэдээллийн өөрийн онцлогоос болж тусгай мэргэжлийн “хаалгач” хүний үйлдэл буурч, дотоод дахь хяналт сулран, хувь хувьдаа эзэн мэддэг болсон болохоор тус салбарт зохиогчийн эрхийг хамгаалах нийгэмлэг байгуулах шаардлагатай байна. Энэхүү нийгэмлэг нь тус салбарын дотоод дахь ажлын тохируулалт, харилцааг хариуцдаг бол, “шампунь”-д хандуулан тусгай мэргэжилтэн нэрийг урьж, “шампунь”-ийг магадлах стандартыг тогтоон, “шампунь” хийгч хүнийг ба интернет сүлжээний технологийн платформыг хангагчдад цохилт өгөхийг багтаасан шийтгэлийн аргаа чангаруулахаар дамжуулж, платформаас өөрийн хяналт ба дотоод дахь хувийн сахилга батыг чангатгахыг ахиулснаар тус асуудлыг шийдвэрлэж болно.

Хувийн сахилга бат бол интернет дэх мэдээллийг эзэмдэх чухал арга гэдгийг хүмүүс явах тусам ойлгосноор “бага интерференц, илүү хувийн сахилга бат” нь өнөөгийн олон улсын нийгэм нийтээс интернет сүлжээний агуулгыг эзэмдэх нэгдэлтэй бодлого болжээ<sup>20</sup>. Гадаадын энэ талаар хөгжсөн улсын олонх нь тус салбарын хувийн сахилга батын байгууллага байгуулсан байна. Эдгээр байгууллагийн зарим нь интернет сүлжээний нийгэмлэг байдаг. Жишээлбэл, Англи Улсын Интернет Сүлжээний Сервис Хангагчийн Нийгэмлэг бол голдуу тус салбарт үүссэн асуудлаа хоорондоо харилцах ба зохицуулан байж шийдвэрлэдэг. Зарим нь захиргааны шинж чанартай төрийн бус байгууллага, байдаг. Жишээлбэл, Австралийн Интернет Анхааруулгын Агентлаг зэрэг байна. Тус салбарын хувийн сахилга батыг чангатгахын тулд, өөрийн селф-хэвлэл мэдээллийн онцлогт тулгуурласан, платформ дамнасан байгууллага байгуулах нь юуны өмнө хийх чухал ажил болжээ.

2. *Хэвлэл мэдээллийнхэн болон үзэгчдийн зохиогчийн эрхийг хамгаалах ухамсарыг дээшлүүлэх.* Уламжлалт хэвлэл мэдээлэл эсвэл шинэ хэвлэл мэдээлэл аль нь байсан ч, ашиг олз хөөцөлдөхийн зэрэгцээд нийгмийн үүрэг хариуцлагаа ухамсарласан байх ёстой. Учир иймээс селф-хэвлэл мэдээллийнхний ухамсарыг дээшлүүлэн, хариуцлагыг нь таниулж, тэдэнд “шампунь”-ийн хор уршгийг мэдүүлэхээр хүч тавих хэрэгтэй. Мөн бусад хүн аль нэгэн зохиолчийн зохиогчийн эрх зөрчсөн байдалд зохиолчоос өөрийн эрх ашгаа идэвхтэй хамгаалах хэрэгтэй. Хэрэв хамгаалахгүй бол эцэстээ буруу эргэлтэнд орох нь дамжиггүй. Зарга заахай дунд хэрэв бүрэн бүтэн гэрч баримттай бол

зарга ялах болож бас ихээр нэмэгддэг юм. Жишээлбэл, 2005 оны Жуан Юйгээс Гуо Жин Минийг заалдсан хэрэг болон 2014 оны Цюн Яогоос Юй Жэнийг заалдсан хэрэг нь бүр “шампунь”-тай зохих хэмжээний харьцаатай болохоор зохиогчийн эрхийг хамгаалах ажилд лавлалтын ач холбогдолтой юм.

Одоохонд “шампунь” нь хар цагааны дундаж бүсэнд байгаа учир, үзэгчид олон зохиогчийн эрхийг хамгаалах ухамсраа дээшлүүлж, санаачилгатайгаар “шампунь” ажиллагааг илчлэн мэдүүлэн, бүх нийгэм нийтийн ухамсрыг бий болгох нь чухал болжээ. Дээрх байдлыг хураангуйлбал, “шампунь”-ийн асуудлыг шийдвэрлэн, селф-хэвлэл мэдээллийн зөв хөгжилтийг бий болгоход хэн нэгний ганц талын хичээл чармайлтаар биш, харин бүх нийгмээрээ хамтран чармайх хэрэгтэй байна.

3. *Холбогдох хууль дүрмийг сайжруулах.* “Шампунь” нь их нуугдмал мөртлөө зохиогчийн эрх зөрчснөөр магадлан тогтооход бэрхшээлтэй байдалд хандуулан хуулийн талаас “Шампунь”-ийг магадлан тогтоох нарийн дүрмийг байгуулан, селф-хэвлэл мэдээлэл дэх зохиогчийн эрхийг хамгаалах хуулийг нарийн тодорхой байлгах ёстой. Соёлын яамнаас Зохиогчийн Эрхийн Хуулийг нийтлэхээс өмнө “Ном зохиол, сэтгүүлийн зохиогчийн эрхийг хамгаалах журмын хэрэгжилтийн дэлгэрэнгүй дүрэм”-ийг нийтлэх үедээ “зохистойгоор эш татах”-ын тухай дүрмийг яруу найргийн зохиол ба яруу найргийн бус зохиолыг эш татах стандарт хэмээн хоёр хуваажээ. Үүнд “зохистойгоор эш татах” гэдэг нь зохиолчоос нэг зохиолдоо бусдын зохиолын хэсгийг эш татахыг хэлнэ. Дээрх дүрэмд тогтоосон нь “Яруу найргийн бус зохиолоос эш татахдаа

2500 үг буюу эшлэгдсэн зохиолын аравны нэгээс хэтэрч үл болно, хэрэв нэг яруу найргийн бус урт зохиолоос олон удаа эш татвал, эшлэсэн үгийн тоо 10,000-аас хэтэрч үл болно. Яруу найргийн зохиолоос эш татвал дөчин мөр буюу бүх шүлгийн дөрөвний нэгээс хэтэрч үл болно, үүнд хуучны хэв маягийн яруу найргийг үл багтаана. Нэг буюу олон хүний зохиолоос эш татахад, эш татсан хэмжээ нь тус зохиолчийн зохиолын аравны нэгээс хэтэрч үл болно, үүнд шүүмжлэлийн монограф ба хуучин хэв маягийн яруу найргийг үл багтаана”. Зохиогчийн Эрхийн Хуулийг нийтэлсний дараа эдгээр журмыг хүчингүй болгосон хэдий ч иймэрхүү ямар нэгэн асуудалд хандуулсан тодорхой дүрэм тогтоол нь зохион байгуулалтын талаас “шампунь”-ийн асуудлыг шийдэхэд лавлах ач холбогдолтой.

4. *“Шампунь”-ийн ажиллагааг таслан зогсоох хүчээ нэмэгдүүлэх.* БНХАУ-ын хуулийн хэрэгжилтийн тогтолцоо дунд засаг захиргааны хууль хэрэгжилт нь чухал нэг хэсэг болдог. “Шампунь” зэрэг зохиогчийн эрх зөрчсөн ажиллагаа нь нуугдмал, зардал бага ордог мөртлөө тэдгээрийг шүүхэд заалдах зардал их байдаг. Харин Зохиогчийн Эрхийн Хуулийн тогтоолоос үзвэл, зохиогчийн эрхээс зөрчсөн ажиллагаа нь “олон нийтийн эрх ашгийг хохироосон” байдал дор зохиогчийн эрхийн засаг захиргааны байгууллагаас захиргаа-ны зохицуулалт хийх ёстой юм<sup>21</sup>. Тиймээс цаг, хүч их зарцуулах уламжлалт маягаар шүүхэд заалдах аргын оронд засаг захиргааны эрх бүхий байгууллагаас тусгай кампанит ажлыг эрчимжүүлэх нь илүү бүтэмжтэй арга юм. Жишээлж хэлэхэд, “Jian net 2018” тусгай ажилд селф-хэвлэл мэдээллийн

“шампунь” ажиллагааг тэмцэх ажил багтжээ. Хоёрдугаар сарын 27 хүртэлх байдлаас үзвэл тус ажил нь нэлээд амжилт олсон байна. Иймээс ийм төрлийн ажилыг илүү явагдуулах нь зохистой арга мөн.

**Дүгнэлт.** Интернет сүлжээ нь хоёр иртэй хутгатай адилхан юм. Түүний нээлттэй, харилцаатай бас нэр тэмдэглэхгүй зэрэг онцлогууд нь хүмүүсийн амьдралыг дөхөм хялбар болгохын хамт “шампунь” мэт зохиогчийн эрх зөрчих асуудлыг бас авчирчээ. Мөн селф-хэвлэл мэдээлэл бий болсноос хойш мэдээлэл түгээгч болон үзэгчдийн хоорондох зааг хязгаар уулынх шиг тодорхой биш болж, хоёр талын харилцааг нэмэгдүүлсэн боловч тусгай мэргэжлийн “хаалгач” хүн дутагдснаас хэвлэл мэдээллийнхний тусгай мэргэжлийн талаарх чанар чансаа доошлжээ. Эдгээр муу байдал нь мөн тус салбарын эрүүл өсөлт хөгжилтийг нөлөөлсөн байна. “Шампунь”-ийн асуудлыг шийдвэрлэхэд холбогдох хууль дүрмийг сайжруулахын хамт засаг захиргааны хууль хэрэгжилтийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Нэн чухал нь, дотоодоо селф-хэвлэл мэдээллийнхний тусгай мэргэжлийн талаарх чанар чансааг дээшлүүлж, хяналтын механизмыг боловсруулан, мэдээлэл түгээгч ба үзэгчдийн зохиогчийн эрхийг хамгаалах үзэл ухамсрыг бий болгоход байгаа юм. Дотоод гадаад хоёр талаас ажлаа гардан, бүх нийгмээрээ хамтран чармайхад “шампунь”-ийг үндсээс нь цэвэрлэн, зохион бүтээх цэвэр орчин байгуулж чадна. “Шампунь” бол харилцаа холбооны ухаан, хууль цаазын ухаан, эдийн засгийн ухаан, сэтгэл зүйн ухааныг хамарсан асуудал болно. Зохиогчийн мэдлэг мөхөс учраас эдийн засгийн, сэтгэл зүйн

ухааны талаас энэхүү асуудлыг задалж чадаагүй мөн хууль цаазын ухааны зах зухаас л ярьсан нь харамсалтай. “Шампунь”-ийн асуудлыг эдийн засгийн, сэтгэл зүйн талаас цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

### Ишлэл

1. Сюй Чунмин: “Шампунь”-ийн тухай хуулийн шинж чанар ба зохицуулалт [N] Шанхай хотын хуулийн сэтгүүл, 2019-02-20 (B05).
2. Жан Вэндэ, Е Нафэн: Сүлжээний мэдээллийн нөөцийг зохиогчийн эрхэд халдаж болзошгүй эрсдлийн шинжилгээ — WeChat платформ дах селф-хэвлэл мэдээллийн “Шампунь”-ийн хэргээр жишээ татвал [J]. Дижитал номын сан BBS, 2017(02):48-51.
3. Интерфэйс мэдээ: WeChat платформ “Шампуньд гомдол гаргах” функц туршин хэргэлсэн, хир тэнцэхгүй зохиолыг уг зохиолоор солих [DB/OL]. <https://baijiahao.baidu.com/s?id=1618828203645570105&wfr=spider&for=pc,2018.12.03>.
4. Сюй Чунмин: “Шампунь”-ийн тухай хуулийн шинж чанар ба зохицуулалт [N] Шанхай хотын хуулийн сэтгүүл, 2019-02-20 (B05).
5. Rightknights: 2018Q3 Зохиолын салбар дах зохиогчийн эрхийн тайлан [R]. Rightknights зохиогчийн эрхийг хамгаалах холбоолол. 2018(10).
6. Rightknights: 2016 Селф-хэвлэл мэдээллийн салбар дах зохиогчийн эрхийн тайлан [R]. Rightknights зохиогчийн эрхийг хамгаалах холбоолол. 2017(10).
7. Ли Сяо: Селф-хэвлэл мэдээлэл дэх зохиогчийн эрхээс зөрчих байдлын тухай бодлогошир — “Жоу Чун-ий Шампунь хэрэг” -ээр жишээлэх нь [J]. Shi Ting, 2019(02):122-123.
8. Пэн Пай мэдээлэл: Жай Тяньлиний магистрийн диплом нь Чэн Кун-ыхыг хуулж уу? Уг зохиолын сайт: [DB/OL]. <https://new.qq.com/omn/>

- [20190217/20190217A0BOX0.html](http://20190217/20190217A0BOX0.html), 2019. 02.17.
9. Хо Сюань, Цуй Синьцин зэрэг: Кино, телевизийн тоглолтын дөрөвдүгээр шат — Тоглолтын мэргэжлийн бакалаврын диплом бичих хичээл [М]. China Film Press, 2005(06):314-320.
  10. Phoenix Entertainment: Цюн Яогоос Юй Жэний хуулсан гэрчийг илчилсэн нь: гурван зохиолын баатрын ирэл гарал жич хоорондох харьцаа нь яг адилхан [DB/OL]. [http://ent.ifeng.com/a/20140415/40014594\\_0.shtml](http://ent.ifeng.com/a/20140415/40014594_0.shtml), 2014.04.15.
  11. Netease Entertainment: тус салбарын найруулагч нар хамтаар Юй Жэнийг илчэлсэн, Лю Я Линээс Юй Жэний хуулах аргыг илчилсэн нь [DB/OL]. <http://ent.163.com/14/0418/05/9Q3DB7UO00032DGD.html>, 2014.04.18.
  12. Суй Пэн. Хэвлэл мэдээллийн шинэ эрин дэх үзэгчдийн үүргийн хувиралтыг шинжлэх нь [J]. Journal of journalism research, 2014(7):182.
  13. Ван Жиган, Зун Бэйбэй. Селф-хэвлэл мэдээллийн зохиогчийн эрхийн асуудлын тухай өгүүлэх нь [J]. News junkie, 2015(08):5-8.
  14. Жу Хунцзюнь. Хяналтын механизмыг дахин байгуулах: селф-хэвлэл мэдээллийн “Шампунь”-ийг цэгцлэх түлхүүр [J]. News and Writting, 2019(02): 70-73.
  15. Яан Линсянь. “Хаалгач” онолыг үгүйсгэсэн BBS цуурхал [J]. Young journalists, 2008(06):76-77.
  16. Гун Чэнбо. Шинэ хэвлэл мэдээллийн удиртгал [М]. China Broadcasting and Television Press, 2012(11):8.
  17. Фан Хаймэй, Гу Липинь. Селф-хэвлэл мэдээллийн платформын “Шампунь” ажиллагааны хууль зүйн асуудал ба зохиогчийн эрхийг хамгаалах асуудал [J]. Publishing Research, 2018(11):5-8.
  18. Тянь Сэньцзе. Селф-хэвлэл мэдээллийн “Шампунь”-ийн асуудлыг шийдвэрлэх бэрхшээл жич арга [J]. News and law, 2018(11):88-89.
  19. БНХАУ-ын зохиогчийн эрхийн хууль, аннотацийн хэвлэл [М]. Law Press China, 2017(08).
  20. Гун Чэнбо, Лю Шу. Шинэ хэвлэл мэдээллийн аноми ба зохицуулалтын онол [М]. China Broadcasting and Television Press, 2010(12):23.
  21. Жу Хунцзюнь, Дин Фу. Хамтын тэмцэл ба дижитал хувиргалт: цаасан хэвлэл мэдээлэл дэх зохиогчийн эрхийн хамгаалалтын зам [J], 2014(05):24-27.

### Summary

With the development of the Internet, people's access to information has become more diverse. The rapid development of a group of self-media platforms represented by WeChat public platform has changed the mode of information dissemination, further reduced the cost of information dissemination and communication, and enriched access to information. At the same time, because of the "shampoo" behavior has a high hidden, low cost, multi-form characteristics, this troubled from the media and even the healthy development of the Internet problems also appear. The main reasons are difficulty of identification at the legal level, the drive of economic interests, the weak supervision of self-media platform, the lack of professional "gatekeeper" from the media, and the lack of strong constraints on both sides, which exacerbates the proliferation of "washing manuscripts" in the media industry. This paper mainly focused on the "shampoo" phenomenon analysis, and from the legal level, industry supervision, public awareness and other aspects of the search for solutions.